



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 07/157

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 44 дүгээр тушаалын 5 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор “Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын навигацийн тоног төхөөрөмж болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт”-ийг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Х.Баттулга	Техник хангалт, навигацийн үйлчилгээ албаны ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	С.Наранбаатар	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Ю.Золзаяа	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Мягмардорж	Монголын Аэронавигацийн инженер техникийн ажилтнуудын холбооны гишүүн
	Ц.Түмэннасан	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Х.Баттулга /-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зерчилгүй гэдгээ илэрхийлэх, зерчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /С.Наранбаатар/-д үүрэг болгосугай.



Л.БЯМБАСҮРЭН